**НИЙСЛЭЛИЙН**
**ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 08 өдөр Дугаар Б/420 Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн Албан бус насан туршийн боловсролын төвийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 408,900 /дөрвөн зуун найман мянга есөн зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн Албан бус насан туршийн боловсролын төв /Д.Дугармаа/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй номыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн Албан бус насан туршийн боловсролын төв /Д.Дугармаа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ҮНЭНБАТ

1119282405 ℡ 2576589

11505000 1249

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын
даргын 2019 оны ..11..сарын ..08.өдрийн .......
А/420 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүрэг, Албан бус-Насан туршийн боловсролын төв

| № | Эд хөрөнгийн нэр | Ашиглалтанд орсон жил | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | ЭБХХХКомиссын хурлын шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ном, сурах бичиг | 2006-2009 | 10-13 жил | ш | 94 | 408,900.00 | 408,900.00 | | | устгах |
| Номын фондын дүн | | | | | 94 | 408,900.00 | 408,900.00 | - | - | |
| Нийт дүн | | | | | | | 408,900.00 | | | |
| Актлах хөрөнгө | | | | | | | 408,900.00 | | | |
| Татан төвлөрүүлэх хөрөнгө | | | | | | | 0.00 | | | |